

ММСГНийгэмлэгийн 2025 оны үйл ажиллагааны тайлан

ММСГНийгэмлэгээс тайлангийн хугацаанд хэрэгжүүлсэн ажлын талаар:

А. Зохион байгуулалт, сурталчилгааны чиглэлээр

1. Нийгэмлэгийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл дээр Удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг авч тусган боловсруулж, УЗ-ийн даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Нийт 26 заалт бүхий төлөвлөгөөний хэрэгжилт 19 ажил бүрэн хэрэгжсэн, 4 ажил огт хэрэгжээгүй, 3 ажил хагас биелэлттэй ерөнхий гүйцэтгэл 79 % байна.
2. Нийгэмлэгийн үйл ажиллагааны 2024 оны тайланг „Төрийн бус байгууллагын тухай хууль”-ийн дагуу Улсын Бүртгэлийн Газарт 2025 оны 2-р сарын 15-ны дотор албан бичгийн хамт нэг цэгийн үйлчилгээний газарт хүргэн өгч ажилласан ба татвар, нийгмийн даатгалын төлбөр, тооцоо, тайланг хуулийн хугацаанд хийж, тайлагнаж ирлээ.
3. Нийгэмлэгийн үндсэн зорилт, үйл ажиллагаа, тайлан болон цаашид хэрэгжүүлэх ажлын талаар гишүүн байгуулагууд, ААНБ, хувь хүмүүст танилцуулах, сурталчлах, гагнуурын мэргэжлийг олон нийтэд түгээх зэрэг ажлууд байнга явууллаа.
4. Мэргэжлийн туслалцаа авах, хамтран ажиллах, ажил төрлийн холбоо тогтоох, сургалтанд хамрагдах, зөвөлгөө авах чиглэлээр нийгэмлэгт хандсан ААНБ, хувь хүмүүст туслалцаа үзүүлж ажиллалаа.
5. Эрчим хүчний салбарын төрийн бус байгууллагуудын төлөөлөл Эрчим хүчний салбарын мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулах асуудлаар 2025 оны 5-р сарын 28-ний өдөр МҮХАҮТанхим дээр хэлэлцэн эрчим хүчний салбарын мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулах тухай санамж бичиг байгуулж, уг холбооны дүрмийн төсөлтэй танилцав. Хуралд ММСГН-ийг төлөөлж гүйцэтгэх захирал Н.Мягмарсүрэн оролцон саналаа хэлж, санамж бичигт гарын үсэг зурав.



6.Гагнуурын мэргэжлийн Монголын анхны, „Гагнуур” сэтгүүлийн 6 дахь дугаарыг дангаар гаргаж гишүүн байгууллагууд, ААНБ, хувь хүмүүст тараан ажиллаж байна. Сэтгүүлийн энэ дугаарт ММСГН Азийн гагнуурын холбооны удирдах зөвлөлийн 42-р хуралдаан болон олон улсын гагнуурын 17-р форумыг Улаанбаатарт зохион байгуулсан талаар болон нийгэмлэгийн үйл ажиллагааны мэдээлэл, ФЛСмидт Монголиа ХХК-ийн засвар үйлчилгээний төвийн менежер М.Батбаярын ярилцлага, “Монгол ур чадвар 2025” уралдааны 2 дахь шатны дүн, гагнуурын шинэ техник технологи, стандарт, гагнуурын мэргэжлийн 6 дахь хичээл зэрэг материалуудыг гаргасан

7.Нийгэмлэгийн www.mmsws.mn веб сайтад нийгэмлэгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол тавьж ажиллаж байна.

8.Боловсрол шинжлэх ухааны яамны уулзалт семинар „Монгол ур чадвар-2025”-ын зохион байгуулах ажлын хэсгийн хурлууд зэрэг арга хэмжээнүүдэд гүйцэтгэх захирал болон нийгэмлэгийн төлөөлөл оролцож санал бодлоо илэрхийлж ажиллав.

9.2025 оны 5-р сард Улаанбаатар хотод Азийн гагнуурын холбооноос зохион байгуулсан АГХ-ны аудиторын шалгалтанд ДЦС-4 ТӨХК, Лайнюкс ХХК, ФЛСмидт ХХК, Хасу Даян ХХК зэрэг байгууллагуудын 8 инженерийг зохион байгуулж оролцууллаа АГХ ы аудитор Номура Соичигийн авсан тестийн шалгалтанд бүгд тэнцээгүй боловч энэ чиглэлээр тодорхой мэдлэг, туршлага олж авсан. Аман шалгалтаар Хасу Даян ХХК чанарын менежер Б.Сэлэнгэ бүрэн тэнцэж Монголын талаас 2 дахь гагнуурын аудитор боллоо.

Б. Атестатчлал, сургалт, стандартын чиглэлээр

1.ГММБС, Эм Пи Ай Консалтантс ХХК, Хасу Даян ХХК, ДЦС-3 ТӨХК, Хасу Солюшн ХХК, Мейжор Дриллинг ХХК, Зэт Эм И ХХК зэрэг 12 байгууллагын болон хувиараа гагнуур эрхлэгч нийт 418 гагнуурчнаас гагнуурын мэргэжлийн атестатчлалын шалгалт авч сертификат, гэрчилгээ олголоо.

2.Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Боловсролын ерөнхий газар,ММСГН НҮТББ, ГММБС хамтран зохион байгуулж буй мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагуудын гагнуурын багш нарын „Сургалт-Хэлэлцүүлэг-Уралдаан” арга хэмжээний хүрээнд 2025 оны 5-р сарын 13-нд гагнуурын багш нарт нэг өдрийн сургалт нийгэмлэгийн зүгээс зохион байгууллаа.

Гагнуурын мэргэжлээр сургалт явуулдаг 36 сургалтын байгууллагын 42 багш сургалт, хөтөлбөрийн хэлэлцүүлэг, ур чадварын уралдаанд хосолсон хэлбэрээр анх удаа оролцов.



Нийгэмлэгээс явуулсан гагнуурын 1 өдрийн танхимын сургалтанд ММСГН-ийн үйл ажиллагааны танилцуулгыг гүйцэтгэх захирал Н.Мягмарсүрэн хийж, гагнуурын ОУ-ын ISO, EN, DIN AWS стандартын тухай Ц.Хашмөрөн /гагнуурын ОУ-ын эксперт ОТ ХХК/, гагнуурын оёдолд гадна үзлэгийн сорил хийх /MNS ISO 17637, MNS ISO 9606-1, MNS ISO 5817/ болон сургалт дадлагын сэдвээр мэргэшсэн инженер О.Мөнхтөгс /Lynux ХХК захирал/, Азийн гагнуурын холбооны гагнуурчны баталгаажуулалтын схем Б.Сэлэнгэ /гагнуурын аудитор Хасу-Даян ХХК/ нарын хичээл орлоо.

3. ММСГН MineSpec ХХК-тай хамтран инженер техникийн ажилтны ахисан түвшний сургалтыг 2025 оны 4-р сарын 28-аас 5-р сарын 2-ныг дуустал тус компанийн байранд зохион байгуулав

Сургалтад Батсэнжид ХХК, Таван хана энерги ХХК, B&U mine ХХК, Sandvik Mongolia ХХК, Recon ndt ХХК MCS property ХХК, Хан алтай ХХК зэрэг 7 компанийн 8 инженер нийт 5 хоног 40 цагийн хичээлд хамрагдлаа.

Хичээлээр гагнуурын эксперт Ц.Хашмөрөн, гагнуурын багш Н.Ганхуяг нар сургалт явуулав.

Сургалтанд хамрагдсан инженер техникийн ажилтнуудад ММСГН-ийн сертификат гардууллаа.



4. ММСГНийгэмлэгээс Оюутолгой компанийн захиалгаар тус байгууллагын ахлах инженер техникийн ажилтнуудад зориулсан сургалт 2025 оны 5-р сарын 13,14 болон 12-р сарын 8,9-ний өдрүүдэд ГММБС дээр зохион байгуулав.

Сургалтаар гагнуур болон үл эвдэх сорилын тухай ерөнхий ойлголттой болгох, өнөөдөр мөрдөгдөж байгаа стандартуудыг танилцуулах, гагнуурын технологийн тухай ойлголт өгөх зорилго агуулсан Сургалтын эхэнд ММСГН-ийн үйл ажиллагааны талаар гүйцэтгэх захирал Н.Мягмарсүрэн танилцуулга хийлээ.

Материал судлалын үндэс, ган, тэдгээрийн бүтэц, ангилал, гагнуурын төрөл, тоног төхөөрөмжийн ангилал, туслах хэрэгсэл, гадна үзлэг, үл эвдэх сорилын арга WPS and PQR тухай ойлголт, ASME,AWS,ASO стандартууд зэрэг сэдвүүдээр ШУТИС-ийн багш доктор Ц.Мөнхтуяа, мэргэшсэн инженер О.Мөнхтөгс, гагнуурын багш Н.Ганхуяг, гагнуурын аудитор Б.Сэлэнгэ нар хичээл орлоо.

Сургалтын эцэст оролцогчдоос Азийн гагнуурын холбооны аудитор Б.Намуундарь, Б.Сэлэнгэ нар тестээр шалгалт авч тус компанийн 7 ажилтанд WELDING MASTER сертификат гардууллаа.



5. 2023 онд ШУТИС-ийн Механик тээврийн сургууль гагнуурын инженер дотооддоо бэлтгэх санаачлага гаргасныг ММСГН дэмжиж хамтран ажилласан.

2025 оны 6-р сарын 5-нд ШУТИС-ийн МТСургууль дээр гагнуурын технологи мэргэжлээр анх удаа 11 хүн бакалаврын зэргээр диплом хамгаалалтаа амжилттай хийлээ. Дипломын сэдвүүд нь станцын өндөр даралт, температурт ажилладаг тоног төхөөрөмж, газрын гүний уурхайн тоноглол, усан доогуур татах шугам хоолой зэргийн элэгдэл гэмтлийг сэргээн засварлах, шинээр хийхэд гагнуурын технологи боловсруулах шийдлүүд байлаа.

Эдгээр суралцагч нь ДЦС-3,4 ТӨХК, ЭУБҮ, Хасу-Даян ХХК зэрэг манай орны эрчим хүч, уул, уурхайн салбарын компанид ажилладаг инженерүүд бөгөөд гагнуурын инженерийн мэргэжлийг оройгоор суралцаж давхар эзэмшив.

Диплом хамгаалалтын комиссын дарга, ММСГН-ийн гүйцэтгэх захирал, МУ-ын зөвлөх инженер Н.Мягмарсүрэн анхны төгсөгчид болон эрдэмтэн багш нарт баяр хүргэж амжилт хүслээ.



В. Мэргэжлийн ур чадварын уралдаан тэмцээний чиглэлээр

1. Ерөнхий зохион байгуулагч Боловсролын ерөнхий газар болон ГММБС-тай хамтран ММСГН мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагуудын гагнуурын багш нарын дунд мэргэжлийн ур чадварын уралдаан зохион байгууллаа.

Аж үйлдвэрийн гавьяат ажилтан Ж.Түмэн-Аюушийн нэрэмжит уг уралдаан цахилгаан, хагас автомат, аргон гэсэн гагнуурын 3 төрлөөр 2025 оны 5-р сарын 15,16-ний өдрүүдэд ГММБС дээр явагдав. Уралдааны нээлтэнд Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, WorldSkills Mongolia НҮТББ УЗ-ийн гишүүн Ц.Чадраабал нар оролцлоо.

Уралдаанд 34 байгууллагын 38 багш оролцсоноос

Цахилгаан гагнуурын төрөлд 35 багш оролцож 1. Б.Алдарцогт /ГММБС/, 2. Мейремгүл /Дархан-Уул аймгийн ПК/, 3. Э.Чулуунхүү /Өмнөговь. Ханбогд Скиллтек МБС/, 4. М.Мөнхтөр /Налайх ПК/, 5. Д.Мөнхбат /Төв. Баянчандмань ПК/

Хагас автомат төрөлд 25 багш оролцож 1. Б.Алдарцогт /ГММБС/ 2. Э.Чулуунхүү /Өмнөговь. Ханбогд Скиллтек МБС/ 3. М.Шүхэрт /Өвөрхангай ПК/ 4. Б.ГанЭрдэнэ /ТТПК/ 5. Б.Батсайхан /Хэнтий ПК/

Аргон гагнуурын төрөлд 10 багш оролцож 1.Б.Алдарцогт /ГММБС/, 2.Б.Ган-Эрдэнэ /ТТПК/, 3.Х.Мейремгүл /Дархан-Уул ПК/, 4.Э.Чулуунхүү /Өмнөговь. Ханбогд Скиллтек/, 5.М.Мөнхтөр /Налайх ПК/ нар тус тус байр эзэлж амжилттай оролцов.

Нэгдүгээр байр 300000 төг, хоёрдугаар байр 200000 төг, гуравдугаар байр 100000 төгрөгийн урамшуулал хүртсэнээс гадна АУГА Ж.Түмэн-Аюуш хувиасаа эхний 3 байр эзэлсэн оролцогчдыг 250000,150000,100000 төгрөгөөр шагналаа.

2. Хэнтий аймгийн Бор-өндөрийн УБҮ-ийн удирдлага, Бор-Өндөрийн мэргэжлийн боловсролын сургуулийн захиргааны хүсэлтээр ММСГН-ээс 2025 оны 4-р сарын 10-11-ний өдрүүдэд гагнуурчдын мэргэжлийн ур чадварын уралдааныг тус суманд хамтран зохион байгуулав.

Тус уурхайн гагнуурчдын ур чадварын уралдаан Бор-Өндөр сумын Мэргэжлийн боловсролын сургууль дээр цахилгаан гагнуур/111/-ын төрлөөр явагдлаа.

Уралдааны удирдамж, техникийн даалгавар боловсруулах, уралдааны зохион байгуулалт, сорьцуудад үнэлгээ хийх ажлыг ММСГН-ийн зүгээс хийж гүйцэтгэв.

Уг уралдааны нээлт,хаалтын ажиллагаанд Бор-Өндөрийн УБҮ-ийн захирал Б.Магсаржав, ХАБЭА-н хэлтсийн дарга Д.Сүхбаатар, ерөнхий механик инженер Ж.Нямсайхан, ЗМТЦ-ийн дарга Н.Батчулуун, Бор-Өндөр МБС-ийн захирал О.Гибрат, сургуулийн арга зүйч А.Мөнхбат нар оролцлоо.

ММСГН-ийн зүгээс гүйцэтгэх захирал Н.Мягмарсүрэн, үнэлгээчин Н.Ганхуяг, Б.Алдарцогт нар ажиллав. Уралдаанд уурхайн нийт 48 гагнуурчин 2,3,4 ба 5,6-р зэрэг гэсэн 2 хэсэгт хуваагдан 108*5 мм-ийн ган хоолойгоор хийсэн сорьц дээр ур чадвараа сорьсон юм.

ММСГН-ийн хараат бус шүүгч үнэлгээчдийн дүгнэснээр 2-4-р зэргийн гагнуурчдаас Э.Сонинбаяр /БФ, Төв корпус/ тэргүүн байр,Г.Итгэлт /ЗМТЦ/ 2-р байр, Ч.Чинтогтох /БФ, ХСБХii/ 3-р байр,

5,6-р зэргийн гагнуурчдаас Ө.Алтаншагай /БФ,Туслах хэсэг/ тэргүүн байр, Л.Чойжамц /ЭХЦДҮХ/ 2-р байр, Л.Цэнд-Аюуш /БФ,Төв корпус/ 3-р байр тус тус эзлэв.

УБҮ түрүүлсэн гагнуурчныг 600000 төг, 2-р байр 400000 төг, 3-р байрыг 200000 төгрөгөөр тус тус урамшуулав.



3.ММСГН НҮТББ „Монгол ур чадвар-2025” гагнуурын мэргэжлийн ур чадварын уралдааны 2-р шатлалын шалгаруулалтыг 2025 оны 12-р сарын 04-06-ны өдрүүдэд ГММБС дээр зохион байгуулж явуулав.

Нээлтийн ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын Мэргэжлийн боловсрол, сургалт хариуцсан арга зүйч мэргэжилтэн Л.Сарангэрэл, Мэргэжлийн боловсрол, сургалтын орчин хариуцсан мэргэжилтэн Алтанчимэг, WorldSkills Mongolia НҮТББ-ын УЗ-ийн гишүүн Э.Батбаяр нар оролцлоо.

Оролцогчид Өмнөговь, Дорноговь, Хэнтий, Ховд, Дорнод, Төв, Увс, Дархан-Уул, Архангай, Булган, Орхон-Уул, Сэлэнгэ зэрэг 12 аймаг болон Улаанбаатар хотын улсын болон хувийн хэвшлийн сургуулиудын суралцагч болон төгсөгчид байв.

Шалгаруулалтыг удирдамжийн дагуу явуулж MNS ISO 9606-1:2021, MNS ISO 5817:2020, MNS ISO 9017:2021, ISO 6947:2019 стандартуудын дагуу үнэлгээ хийж дүгнэлээ. Шалгаруулалтанд 1-р шатлалаас шалгарсан 22 сургуулийн 22 оролцогч гагнуурын 3 төрлөөр /цахилгаан (111), хагас автомат хатуу утсаар (135), аргон нуман гагнуур (141)/ өрсөлдлөө.

Оролцогч бүр 3 сорьц гагнасан. Үүнд: ган хоолой D60*4 mm, хавтан 10 mm, тулгасан холболт хавтан 12 mm булан холболтыг гагнуураар хийж гүйцэтгэв.

Өрсөлдөгчдийн нийт 66 ш сорьцыг гадна үзлэг, дотоод үзлэг /рентген шалгалт/, эвдэх сорилоор шалгаж үнэлэв. Шүүгчдийн үнэлгээгээр:

М.Сүхбат /ГММБС/ авбал зохих 25.8 онооноос 21.1 оноо /83.8%/ авч 1-р байр,

Э.Мягмардорж /ТТПК/ 18.8 оноо /72.9%/ 2-р байр,

Г.Номин /Өмнөговь ПК/ 12.8 оноо /49.6%/ авч 3-р байр, Э.Баяржавхлан /Налайх ПК/ 11.4 оноо /44.2%/ 4-р байр, Э.Буянжаргал /Дархан ПК/ 4.2 оноо /16.3%/ 5-р байр тус тус эзэлж дараагийн 3-р шатны уралдаанд орох эрх авлаа.



4.БНХАУ-ын Гаоми хотод 2025 оны 9-р сарын 5-10-ны өдрүүдэд мэргэжлийн гагнуурчдын ур чадварын ARC CUP-2025 тэмцээн зохион байгуулагдлаа.

ММСГН мэргэжлийн гагнуурчдын 2024 оны улсын аваргын тэмцээний шилдгүүдээс бүрдсэн 5 гагнуурчин бүхий багийг ГММБС-ийн захирал Э.Гантулгаар ахлуулан оролцуулав.

Тэмцээнд Энэтхэг, Киргизстан, Гана, Сенегал, Монгол зэрэг орнууд оролцсон гадаадын багуудыг тусад нь дүгнэж байр эзлүүлсэн.

Тэмцээний дүнгээр М.Сүхбат /Хасу Даян ХХК/ цахилгаан гагнуурын төрлөөр 3-р байр, хийцийн төрлөөр 2-р байр, Д.Нямрагчаа /МЭЗ ХХК/ хагас автомат төрөлд 1-р байр, хийцийн төрөлд 1-р байр, Х.Бямбажав /MCS Property ХХК/ цахилгаан гагнуур 2-р байр, хагас автомат 3-р байр, З.Норовбат /MCS Property ХХК/ цахилгаан гагнуур 1-р байр, аргон гагнуур 1-р байр, Э.Бат-Эрдэнэ /Тепло сервис ХХК/ цахилгаан гагнуураар тусгай байрт орон багийн дүнгээр алтан цом авч сайхан амжилт гаргалаа.

Тэмцээний үеэр "Гагнуурын технологийн хэрэглээ ба техникийн ур чадварыг хөгжүүлэх нь" нэрийн дор явагдсан олон улсын семинарт ММСГН-ийг төлөөлж ГММБС-ийн захирал Э.Гантулга "Welders certification system and related standards of Mongolia" сэдвээр илтгэл тавив.



Г. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр

1.ММСГНийгэмлэг АГХолбооны бүрэн гишүүний хувиар үйл ажиллагаанд нь оролцож, гишүүнчлэлийн хураамжаа цаг тухайд нь төлж ажиллаж байна.

2.Азийн гагнуурын технологи ба түүний хэрэглээний 17 дахь форумыг Улаанбаатар хотод 2025 оны 5-р сарын 22-нд анх удаа амжилттай зохион байгууллаа. Азийн гагнуурын холбооны ээлжит 42-р хуралддааны хүрээнд хийгдсэн тус форум ГММБС дээр явагдаж, ММСГН ерөнхий зохион байгуулагчаар ажиллав.

„Гагнуур, сургалт ба холбогдох техникийн шийдлүүд” нэрийн дор явагдсан тус форумд Азийн гагнуурын холбоо /AWF/, Япон, БНХАУ, Малайз, Индонез, Тайланд, Энэтхэг, Монголын гагнуурын нийгэмлэгийн удирдлага, гишүүд оролцлоо.

Форумын оролцогчдод ММСГН-ийн гүйцэтгэх захирал Н.Мягмарсүрэн мэндчилгээ дэвшүүлж, Азийн гагнуурын холбооны ерөнхийлөгч ноён Махажан Сатеендэр уг арга хэмжээг нээж үг хэлэв

Хуралд Монгол, Япон, Малайз, БНХАУ, Индонез, АГХолбооны төлөөллүүд нийт 9 сэдвээр илтгэл тавилаа.

Монголын талаас 4 илтгэлийг ММСГН, ГММБС, Lynux ХХК, Зэт Эм И ХХК, Хасу Даян ХХК-ийн оролцогчид бэлдэж тавьсан.

Хурлын илтгэлүүд нь гагнуурчдыг шалгаж баталгаажуулах, гэрчилгээжүүлэх систем, гагнуурчдын сургалт, гагнуурын чанарыг дээшлүүлэх, стандартын талаар болон уул уурхай, эрчим хүч, далайн тээврийн салбарт гарсан хүндрэлтэй асуудлуудыг шийдсэн гагнуурын технологи зэргийг хөндсөн сэдвүүд байлаа.

Форумд оролцогчид ГММБСургууль болон Lynux ХХК-ийн үйл ажиллагаатай танилцав.



3.Азийн гагнуурын холбооны ээлжит 42-р хурлыг ММСГН 2025 оны 5-р сарын 23,24-ний өдрүүдэд Улаанбаатар хотын Туушин зочид амжилттай зохион байгууллаа.

Хурлыг АГХолбооны ерөнхийлөгч Махажан Сатеендэр /Энэтхэг/ нээж, ММСГН-ийн гүйцэтгэх захирал мэндчилгээ дэвшүүлэв. Хурлыг АГХ-ы нарийн бичгийн дарга удирдаж явууллаа.

Хуралд АГХ, Япон, Сингапур, БНХАУ, Малайз, Тайланд, Индонез, Монголын гагнуурын нийгэмлэг, институтын удирдлага, төлөөлөл оролцлоо.

Тус хурлаар АГХ-ы аудит, бичиг баримт, стандарт, гэрчилгээжүүлэлт, веб сайт, боловсрол сургалт зэрэг салбар хороодын илтгэл танилцуулга хийгдсэн. Гагнуурчдыг шалгаж, баталгаажуулж, гэрчилгээ олгох систем, нэгдсэн нэг стандарттай болох, гагнуурчдын сургалт, ур чадварын тэмцээн уралдаан зэрэг сэдвүүдээр хэлэлцүүлэг өрнүүлэв.

Мөн АГХ-ы санхүүгийн нөөц, орлого, зарлагыг танилцууллаа.

Хэлэлцэж буй асуудлуудаар гишүүдийн саналын тусгаж эцэслэн батлав.



4. Азийн гагнуурын холбооны 43-р хурал 2025 оны 10-р сарын 24-26-ний өдрүүдэд БНХАУ-ын Nanning хотод боллоо. Хуралд Япон, БНХАУ, Энэтхэг, Сингапур, Малайз, Монгол, Вьетнам, Индонез, Тайландын гагнуурын нийгэмлэгийн удирдлага, төлөөлүүд оролцов.

Хурлаар АГХ-ы 42-р хурлын шийдвэрүүдийн хэрэгжилт, цаашид хийх ажлуудаар тус холбооны аудит, стандарт, веб сайт техникийн салбар хороодын илтгэл хэлэлцэж хийх ажлын төлөвлөгөө батлав.

ММСГН-ээс 5 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөл оролцлоо.

Хурлын үеэр Азийн гагнуурын технологийн 18-р семинар /форум/ 10-р сарын 25-нд тус хотын Машин механизм, цахилгаан технологийн коллеж дээр болж гагнуурын салбарын хөгжил, хүний нөөц, сургалт, техникийн дэвшил, гагнуурын технологийн шийдлүүд зэрэг сэдвүүдээр 8 орны төлөөлийг хамарсан 18 илтгэл сонслоо.

ММСГНийгэмлэгийн зүгээс „Даралтат шугам хоолойн гагнуурын чанарын хяналт ба стандартын хэрэгжилт” сэдвээр аудитор Б.Сэлэнгэ илтгэл тавьж оролцов.



5. БНХАУ-ын Nanning хотод 2025 оны 10-р сарын 26-ны өдөр ММСГН, Японы гагнуурын инженерийн нийгэмлэгтэй хамтран Монгол улсад гагнуурын зохицуулагчдыг гэрчилгээжүүлэх JWES батламжийн тогтолцоог хэрэгжүүлэх хамтын ажиллагааны гэрээ үзэглэлээ.

Уг гэрээний дагуу 2026 оны 11-р сард Монголын гагнуурын инженерүүдийн мэдлэг, мэргэжил дээшлүүлэх 20 хүртэлх хүний 7 хоногийн сургалтыг Улаанбаатар хотод явуулна.

Хамтын ажиллагааны гэрээнд Японы гагнуурын инженерийн нийгэмлэгийн гүйцэтгэх захирал Seiichi Daimaru, ММСГН-ийн гүйцэтгэх захирал Н.Мягмарсүрэн нар гарын үсэг зурав.



6. АНУ-ын Чикаго хотын McCormick ордонд 2025 оны 9-р сарын 8-11-нд болсон хойд Америкийн хамгийн томд орох Металл боловсруулалт, үйлдвэрлэл, гагнуур огтолгооны олон улсын FABTECH- 2025 үзэсгэлэн яармагт Монголын үндэсний үйлдвэрлэгчдийн төлөөллийг оролцуулах ажлыг ММСГН зохион байгууллаа.

Уг үзэсгэлэнд технологийн 40-өөд төрлийн 1500 гаруй үзмэр үүний дотроо хамгийн сүүлийн үеийн лазер огтолгооны технологи, робот гагнуур, автомат систем зэргийг газар дээр нь ажиллуулж танилцуулжээ.

Үзэсгэлэнд МЭЗ ХК-ийн захирал Д.Ганбаатар, Хасу Даян ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Ганхөлөг, ерөнхий менежер Х.Нямжав, Оюутолгой дахь ДТС-ын дарга Д.Энхбаяр нарын бүрэлдэхүүнтэй баг оролцож орчин үеийн техникийн дэвшил тус салбарт гарч буй техникийн сонгодог дэвшлүүдийг үзэж танилцав.



Улаанбаатар хотод болсон Азийн гагнуурын 42-р хурлын зардлын нийт хандив: 18,500,000 төгрөг

Хандивын задаргаа: Хасу Даян ХХК - 10,000,000 төгрөг

Зэт Эм И ХХК - 5,000,000 төгрөг

Хасу Металз ХХК – 1,500,000 төгрөг

МЭЗ ХХК - 2,000,000 төгрөг

Дүрэмд заасан орлого – 137,338,738 төгрөг

Нийт ажиллагааны зардалд-168,836,783.37 төгрөг

Тайлан бичсэн

Н.Мягмарсүрэн/



Төрийн бус байгууллагын хаяг: Баянгол дүүрэг 20-р хороо Эрчим хүчний гудамж-50 Хасу-Мегаваттын байр
Удирдах зөвлөлийн даргын Ж.Түмэн-Аюушийн хаяг: Хан-Уул дүүрэг 11-р хороо 2-р хэсэг Лагшири Зайсан
виллаж 5-р байр 5 тоот

Гүйцэтгэх захирал Н.Мягмарсүрэнгийн хаяг: Баянгол дүүрэг 6-р хороо 10-р хороолол ХД-58 байр 01 тоот